



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 4/19

Хужирт сум

Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн  
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд  
зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны “Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авах зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай А/33 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архи, согтууруулах ундаа худалдах борлуулах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хориглож, лацдах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Доржсэмбэ) нарт тус тус үүрэг болгосугай.

2. Шатахуун түгээх станцуудын нийтийн эзэмшлийн талбайг стандартын дагуу камержуулан, ажилтнуудыг халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Э.Оюунпүрэв) нарт тус тус даалгасугай.

3. Халдварт хамгааллын дэглэм зөрчиж үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоож хариуцлага тооцохыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр)-д үүрэг болгоугай.

4. Гамшигаас хамгаалах бэлэн байдлыг хангаж ажиллахыг сумын Эрэн хайх, аврах бүлгийн дарга, ажиллагааны зааварчлагч Д.Баянсан, Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМОНХ

250100037